

МАТЕМАТИК, ХИМИ



Математикийн лавлах /Эмх. Г. Даариймаа, Хян. Б. Цэндсүрэн. – УБ.: 2008. – 215 хууд.

Математикийн лавлах номд аналитик геометр, шугаман алгебр, математикийн анализын үндсэн ухагдахууныг товч тайлбарлажээ. Дээд математикийг бие даан суралцагчид болон математикийг хэрэглэхийг хүссэн хэн боловч ашиглахад хялбар дөхөмтэй энэ лавлахыг оюутан сурагчдад зориулсан болно.

22.1я2

М-29

/БШУН унш-15ш/

Б-20976-20980

Сангаа Д. **Бодисын нано кристалл бүтэц** /Ред. Т. Галтбаатар. – УБ.: Цоморлиг, 2011. – 415 хууд.

Энэхүү эрдэм шинжилгээний нэг сэдэвт бүтээлд янз бүрийн төлөвт орших бодисын бүтцийн мөн чанар, тэдгээрийн симметр зүй тогтол, нано кристалл бүтэц үүсэх нөхцөл, шалтгаан, устөрөгчит энергийн үүсгүүр, хатуу түлш /fuel cell/-ний ажиллах зарчим хэрэглээ зэрэг сүүлийн үед анхаарал татаж буй олон асуудлыг орчин үеийн физикийн онол, эгэл бөөмс, цөмийн физикийн тулгуур ойлголтууд, математикийн группын онолыг ашиглан шинжлэх ухааны ойлгомжтой хэлбэрээр тайлбарлажээ.



22.37

С-29

/БШУН унш-24ш/

Т-14688-14693



Биндэрья М., Бөхчулуу М., Гарамжав А. **Эмийн ургамлаас биологийн идэвхт бодисууд ялгах аргачлал.** –УБ.: Шидэт өнгө, 2011. -208х.

Эмийн ургамал судлаач химичид, эм зүйн төгсөлтийн болон төгсөлтийн дараах сургалтын оюутнууд, эм зүйч нарт зориулагдсан энэхүү номонд ургамлын түүхий эдийг шинжилгээнд бэлтгэх, дан бодисуудыг таньж тодорхойлох, витаминууд, антрацений уламжлал ба түүний глюкозууд, кумаринууд, идээлэгч бодисууд, органик хүчлүүд, ургамлын эслэг, ургамлын тос ба хандлагдах бодис, чийг, үнслэг

тодорхойлох аргуудын тухай өгүүлнэ.

24.239я73

Б-48


/БШУН унш-15ш/

Т-14816-14820

ГЕОЛОГИ, ГАЗАРЗҮЙ

Балжинням В. **Эрдэс ба чулуулаг** /Хян. Ж. Лхамсүрэн. – УБ.: Интерпресс, 2010. – 232 хууд.

Энэ гарын авлага нь эрдэс, чулуулаг гэсэн 2 бүлгээс бүрдэнэ. Энэхүү дээжинд энгийн нүдэнд илрэх төрөл бүрийн шинжүүд бичигдсэн учир эрдэс, чулуулгатай харьцдаг геологич нар, геологи, геофизик, гидрогеологи, өрөмдлөг, газрын тосны мэргэжлээр суралцагсад, сургалтын болон хээрийн дадлагын явцад эрдэс, чулуулгыг тодорхойлоход зориулагдана. Эрдэс, чулуулгын үүсэн бүрдэх, хэлбэршин тогтносон дүрс төрх, байрших хэлбэр, бүтэц, өнгө зүс олон янз болох нь дээжийн зургуудаас харагдана.



26.31

Б-22

/БШУН унш-15ш/

Б-20951-20955



Газарзүй III. Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн 9-р ангийн сурах бичиг /Баянтөр М. ба бус. –УБ.: 2011. -124х.

ЕБС-ийн 9-р ангийн Газарзүй I, II сурах бичигт дэлхийн болон Монгол орны байгалийн онцлог, байгалийн үзэгдэл, юмсын зүй тогтлын тухай өгүүлсэн ба энэхүү Газарзүй III-г Монголын нийгэм эдийн засгийн газарзүйн үндсэн ойлголтуудын тухай өгүүлэх болно.

26.8я721

Г-16

/БШУН унш-12ш/

Т-14712-14714

Газарзүйн мэдээллийн системийн үндэс /Орч. Ред. М. Батцэнгэл, Д.Амарсайхан, О.Алтансүх, Ч.Болорчулуун. – УБ.: 2011. – 247 хууд.

Газарзүйн мэдээллийн систем ном нь нийт 7 бүлгээс бүрдэх ба бүлгийн дэс дараалал ГМС –ийг судлагчдад энгийн ойлгомжтой болгож өгчээ. Үүнд: байгалийн олон янзын үзэгдэл, тэдгээр юмс үзэгдлийг ГМС –ийн тусламжтайгаар хэрхэн дүрсэлж болохыг, газарзүйн мэдээлэл, өгөгдөл боловсруулах систем, орон зайн мэдээний чанар, дэлхийн орон зайг тодорхойлогч тогтолцоо, байршлын алдаа болон хиймэл дагуулд суурилсан байршил тогтоох систем, орон зайн мэдээг цуглуулах, системд оруулах, харэглээнд бэлтгэх, орон зайн мэдээг удирдан зохион байгуулснаар бидний танин мэдсэн байгалийн юмс үзэгдлийн тухай ойлголтыг хэрхэн дээшлүүлэх, мэдээг хэрхэн ойлгомжтой, энгийн янз янзын байдлаар дүрслэн харуулж болдгыг олон талаар хуваан авч үзжээ.



26.82

Г-16

/БШУН унш-15ш/

Т-14699-14703



Даш Д. Монгол орны ландшафт-экологийн асуудлууд: 2 дахь хэвлэл. –УБ.: 2010. -415х.

Энэ ном нь 2000 онд хэвлэгдсэн номны 2 дахь хэвлэл бөгөөд уг бүтээлд ландшафт судлал, тусгай хамгаалалттай газар нутаг, байгалийн аялал жуулчлал, цөлжилт, байгаль хамгааллын чиглэлээр туурвисан гол бүтээлүүдийг эмхэтгэн оруулжээ. Энэхүү эмхэтгэлийг оюутан сурагчид, эрдэм шинжилгээний ажилтан, газарзүйг сонирхогч хэн бүхэн гарын авлага болгон ашиглах боломжтой ажээ.

26.82/1/

Д-39

/БШУН унш-7ш/

Т-14833-14835

Лувсанданзан Б. Геологийн үндсүүд: 2 дахь хэвлэл. –УБ.: Мөнхийн үсэг, 2011. - 175х.

Геологийн үндсүүд хэмээх энэ номонд газар дэлхийн нүүр царайг эрин цагаар байнга өөрчилж байдаг геологийн олон янзын үзэгдэл үйл явцын үр дагаварын талаар өгүүлнэ. Энэхүү ном нь анх 1964 онд хэвлэгдсэн бөгөөд энэ удаад зарим нэг зураг, тоо баримтыг нэмж засварлан дахин хэвлүүлж байна.


26.3

Л-82

/БШУН унш-15ш/

Т-14836-14840





Лхагвасүрэн Ж. **Монгол орны эрдэс, ашигт малтмал**: Фото зураг. – УБ.: Мөнхийн үсэг, 2011. – 130 хууд.

Монгол орны газрын хэвлий нь зүйл бүрийн эрдэс, ашигт малтмалаар багагүй баялаг юм. Эрдсийн хуримтлал үүссэн газруудад алт, мөнгө, зэсийн хүдэр, холимог металл, ховор металл ба ховор шорооны элементүүдийн хүдэр, төмөр, вольфром, хайлуур жоншны хүдрийн хуримтлал, барилгын үйлдвэрлэлийн түүхий эд болох олон зүйлсийн эрдэс чулуулаг, давс, нүүрс тэргүүтний зургаан мянга гаруй орд, илрэлүүд манай нутгаар мэдэгдээд, судлагдаж зарим нь ашиглагдаж байна. Байгальд өрнөж ирсэн геологийн олон талт үйл явцын нарийн үзэгдлүүдийг тольдон харуулдаг байгаль эхийн урлан болох эрдсийн бүтэц бүрэлдхүүний зүйл бүрийн дүрс, өнгө төрлийн хослолыг та бүхэн энэхүү зургийн цомгоос уншиж, харж мэдэх болно.

26.31я6

Л-87

/БШУН унш-2ш/

Т-14717-14718

Равдан Э, Нарангарав Ж. **Монгол газар нутгийн нэрийн хувьслын толь** /Хян. Г. Лувсан, Ч. Батсүрэн. – УБ.: Удам соёл, 2011. – 587 хууд.


Уг толь бичиг нь бүтцийн хувьд өөр хоорондоо холбоо бүхий хоёр толиос бүрджээ. Эхнийх нь Манж, Богд хаант Монгол улсын үеийн 260 зурагт туссан нэрийг 1:200 000 масштаб бүхий 316 газрын зургийн нэртэй үндсэн 4 аймгаар нь зүйл хуваан хэлхсэн толь, удаах нь Монгол улсын үлдсэн гурван үеийн зурагт тэмдэглэгдсэн нэрийг өөр хооронд нь дүйлгэн үзэж крилл үсгээр дарааллагдсан толь болно. Толийг хуваасан учир нь монгол уламжлалаар бүтсэн газрын зураг, хожим хэвлэгдсэн, орчин үеийн зургын ялгаа, нэр тэмдэглэсэн байдал, бүтэсэн цаг хугацаа, тухай тухайн үеийн засаг захиргааны хуваарь нь өөр өөр байсантай холбоотой аж. Ийнхүү хувааж үзсэн нь толь ашиглах хүний хөдөлмөрийг хөнгөвчилөх болно.



26.8/1/я2

Р-13

Т-14696-14698



Сайнбаяр Б. **Эрдэс чулуулаг**: Хээрийн хөтөч /Ред. Ж. Бямба. – УБ.: 2011. – 220 хууд.

Бид эх дэлхийгээ танин мэдэхийн тулд чулуулаг ба түүнийг бүрдүүлж байгаа эрдсийг таних шаардлагатай билээ. Амьгүй байгалийн сонирхогч хэн бүрийн мэдэж байвал зохих анхан шатны ойлголт болох дэлхийн бүтэц, найрлага, түүний хөгжлийн түүхийн тухай мэдлэгийг ойлгомжтой хэлбэрээр эхний хэсэгт өгүүлэх ба дараагийн бүлгүүдэд эхлээд эрдэс, дараа нь тэдгээр эрдсээс бүтэх чулуулгийн гарал үүслийг бүлгээр нь ангилсан болно. Мөн хөгжилтэй орнуудад хэвлэгдэж, нийтийн хүртээл болгож байдаг сурталчилгаа, танин мэдэхүйн олон бүтээлүүдээс сонгон оруулжээ.

26.31

С-17

/БШУН унш-15ш/

Б-20981-20985

ГЕНЕТИК, МОЛЕКУЛ БИОЛОГИ

Батбаяр Д. **Генетикийн бодлого бодох аргачлал** /Ред. С. Шар. – УБ.: Соёмбо принт, 2011. – 81 хууд.


Их, дээд сургуульд биологийн мэргэжлээр суралцаж буй оюутнууд, ерөнхий боловсролын сургуулийн биологийн багш нар, биологийн олимпиадад бэлтгэгчдэд бодлого дасгалын гарын авлага дутагдаж, мөн элсэлтийн ерөнхий шалгалт, олимпиадын бодлогын түвшин улам өндөр болж байгаатай уялдуулан генетикийн бодлого бодож сурахад нь хувь нэмэр өгөх үүднээс зориулж гаргасан байна.



28.04

Б-33

Б-20961-20963



Молекул биологийн үндэс: Сурах бичиг /Х.Алтанцэцэг, Н.Туул, Э.Доржпагма, С.Отгонсүрэн. –УБ.: Битпресс, 2011. -168х.

Их дээд сургуулийн биологийн чиглэлээр сурч буй оюутан сурагчдад зориулагдсан энэхүү сурах бичигт молекул биологийн үндэсийг биологийн загвар систем, биологийн макромолекулуудын бүтэц, тэдний үүрэг, эс дэх макромолекулуудын үүргийн зохицуулалт, молекул биологийн практик хэрэглээ гэсэн 6 бүлэгт хуваан авч үзжээ.

28.070я73

М-68

/БШУН унш-3ш/

Т-14827-14829

НҮҮРСНИЙ ХИМИ, ОЙ СУДЛАЛ, МАЛ ЭМНЭЛЭГ

Нарангэрэл Ж. **Нүүрсний хими, технологийн үндэс.** –УБ.: Адмон, 2011. -388х.


Энэ номонд нүүрсний гарал үүсэл, төрөл, петрограф, бүтэц, найрлага, физик химийн шинж чанар, анхан шатны хэрэглээ, гүнзгий боловсруулалтын технологүүд, коксжуулалт, хийжүүлэлт, шингэрүүлэлтийн талаарх орчин үеийн шинжлэх ухааны үндсэн мэдлэг, ойлголтуудыг хамруулан оруулжээ. Мөн түүнчлэн нүүрс ба түүний бүрдэл хэсгүүдийн химийн шинжилгээний ерөнхий зарчим, аргачилал, орчин үеийн ангилал, дэлхийн нүүрсний нөөц, тархалтын байдал, олборлолт, байгаль орчинд үзүүлэх нөлөөллүүдийн талаарх мэдээллийг багтааснаараа нүүрсний чиглэлээр ажилладаг эрдэмтэн судлаачид, багш оюутнуудад гарын авлага болох ажээ.

35.512

Н-29

/БШУН унш-3ш/

Т-14830-14832



Энэбиш Д. **Ойжуулалтын ажлын арга технологи: 4 дэх хэвлэл** /Ред. Н. Гомбосүрэн, Ц.Банзрагч. – УБ.: Битпресс, 2011. – 299 хууд.

Энэ номонд мод бутны үр бэлтгэх, тарьц суулгац үржүүлэх, ойжуулалт хийх, хамгаалалтын ойн зурвас байгуулах, хот сууринг цэцэрлэгжүүлэх, жимс жимсгэнэ үржүүлэх арга ажиллагааг өгүүлнэ. Номыг их, дээд сургуулиудын оюутнууд, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн сурагчид сурах бичгийн энэ ажлыг гарын авлага болгох зорилгоор ашиглаж болно.

43

Э-66

/БШУН унш-7ш/

Б-20986-20988

Өлзийтогтох Ц. **Биобэлдмэлийн гарын авлага**: Мал эмнэлэгийн зориулалттай вакцин, оношлуур, эсрэг ийлдэс. – УБ.: Ном хур, 2010. – 217 хууд.

Энэхүү гарын авлагыг хэрэглэх зааварт нь манай улсад үйлдвэрлэж байгаа мал эмнэлэгийн зориулалттай вакцин, эсрэг ийлдэс, оношлуурын талаархи суурь мэдээллүүдийг малын эмч, мал эмнэлэг биотехнологийн мэргэжлээр суралцаж, ажиллаж буй оюутан, мэргэжилтэн, судлаач нарт болон тухайн бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд ямар нэгэн хэмжээгээр тусламж болж өгнө.




48

Б-49

Б-20959-20960

ЭРҮҮЛ АХУЙ



Мэдэхэд илүүдэхгүй: Ашигтай зөвлөгөө /Эмх. Ц.Итгэл. –УБ.: 2011. –628х.

Хал үзэж хашир суусан ахмад буурлуудын үг, тэднээс удаан жил аж амьдралдаа сонсож, хэрэглэж ирсэн туршлага, сайн үр дүнгээ өгсөн зүйлс, эм эмчээс хол хөдөөгийн эгэл бор амьдралтай хүмүүс гарын доорхи зүйлийг ахуй амьдралдаа хэрэглэж ирсээр байгаа билээ. Энэ л ахуй амьдралын туршлага, эрүүл мэндийн зөвлөгөө, зөвлөмжүүдийг залуу үеийнхэн болон нийт уншигчдад амьдралд хэрэг болох үүднээс эмхэтгэн толилуулж байна.

53.51

М-94

/БШУН унш-3ш/

Б-20793-20794



Оюунгэрэл Ц. **Гэрт болсон яриа** /Ред. Б. Янжмаа, Г. Тогтох, Л. Эрдэнэчимэг. – УБ.: 2011. – 183 хууд.

Энэ номд зохиогч Ц. Оюунгэрэл нь өөрийнхөө гэрт болж тохиолдсон үйл явдлаас үүдэн биеийн эрүүл мэнд, мэдээллийн талаар судалж мэдсэнээ өргөн олон уншигчдадаа зориулан бичжээ

51.1/1/6

О-63

/НХШУН унш-3ш/

Б-20946-20947

СТАТИСТИК ШИНЖИЛГЭЭ

Чимгээ Д. **SPSS: нийгмийн статистикийн шинжилгээ хийх, үр дүнг тайлбарлах нь**: 3 дахь хэвлэл. –УБ.: “Арвай бурхан”. 2011. –247х.

Оюутан, багш, эрдэмтэд, нийгмийн олон талын судлаачид болон нийгмийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагын ажилтан, асуудал хариуцсан мэргэжилтэнүүд болон хувь хүн ашиглах боломжтой энэхүү номонд өгөгдөл цуглуулах, өгөгдлийн бүтэц, нийгмийн статистикийн үндсэн ойголтууд, тайлбарлах арга зүйг авч үзжээ.



60.6

Ч-62

/НХШУН унш-15ш/

Б-20845-20849

ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ УХААН



Болдбаатар Ж. **Монголын 1911 оны үндэсний хувьсгалын зүтгэлтнүүд** /Хян. С. Чулуун. – УБ.: Адмон, 2011. – 432 хууд.

Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, түүхийн ухааны доктор, профессор, академич Ж. Болдбаатар энэхүү бүтээлээ Монголын 1911 оны үндэсний хувьсгалын 100 жилийн ойд зориулжээ. Тус номын эхний хэсэгт: Монгол төрийн зүтгэлтнүүдийн түүхэн хэв шинжийг тодорхойлох арга зүйн асуудал, дараах хэсэгт: Богд Жавзандамба, чин ван Ханддорж, Да лам Цэрэнчимэд, гүн Хайсан нарын тухай тусгай бүлэг болгон өгүүлээд, үндэсний хувьсгалын бусад есөн зүтгэлтний амьдрал, үйл ажиллагааны тухай дүгнэн бичжээ.

63.3/1/6

Б-5

Болдбаатар Ж. **Эрдэнэ дайчин хошой чин ван Ханддорж** /Эрх. Б. Гүнбилэг. – УБ.: Мөнхийн үсэг, 2011. – 281 хууд.

Академич Ж. Болдбаатарын туурвисан энэхүү бүтээлээс хошой чин ван Ханддоржийн амьдрал, тэмцлийн тухай төдийгүй тухайн цаг үеийн монголын нийгмийн төрх байдал, 1911 оны үндэсний хувьсгалын ялалт, үр дүн ямар их үнээр олдсоныг танин мэдэж, түүхэн сурвалжуудаас нь мэдрэх болно. Чин ван Ханддорж бол Монгол улс XX, XXI зуунд сэргэн мандах үндэс суурийг тавьж өгснөөрөө түүхэн гавьяатай хүн юм. Уг бүтээлийг судлаач эрдэмтэд болоод өргөн олон та бүгдэд уншиж судлахад тань сонирхолтой ном болжээ.

63.3/1/6

Б-54

/НХШУН унш-3ш/

Б-20799-2080



Монгол улсын нутаг дэвсгэр, хил хязгаар 1911-1919: Баримтын эмхтгэл /Эмх. Б. Пунсалдулам, Э. Жигмэддорж, Ред. Ж. Урангуа. – УБ.: Согоонуур, 2011. – 129 хууд.


Тус эмхтгэлд XX зууны эхэн үеийн монголчууд өөрсдийн газар нутаг, хил хязгаараа хамгаалахын төлөө явуулсан тэмцэл, тухайн цаг үеийн Монгол улсын нутаг дэвсгэр, хил хязгаарын түүхэнд холбогдох архивын данс хараа, хууль цаазын бичиг, түүхийн сурвалж зохиолд тэмдэглэн үлдээсэн баримт сэлтийг багтаасан болно.

63.3/1/6

М-69

/НХШУН унш-3ш/

Т-14763-14764



Монголын угсаатны зүйн хээрийн судалгааны эх хэрэглэгдэхүүн: 1-10р боть /Эрх. С.Чулуун., Эмх. Д.Түвшинзаяа. –УБ.: Соёмбо принтинг, 2011.

Энэхүү 10 боть номонд 1950-1989 оны Монголын угсаатны зүйн хээрийн судалгааны тайлангуудыг бүрэн эхээр нь оруулсан ба мөн угсаатан зүйчдийн товч намтарууд тус тус оржээ. Судалгааны энэхүү эх хэрэглэгдэхүүн нь Монгол угсаатныг судлагч хэн бүхэнд гарын авлага болох ажээ.

63.5/1/

/НХШУН унш-3ш/

М-69

1-р боть: 1960-1971он. -433х.

Т-14789-14790

2-р боть: 1971-1972он. -382х.

Т-14791-14792

3-р боть: 1973-1977он. -356х.

Т-14793-14794

4-р боть: 1977-1978он. -384х.

Т-14795-14796

5-р боть: 1979-1982он. -523х.

Т-14797-14798

6-р боть: 1981-1982он. -380х.

Т-14799-14800

7-р боть: 1982-1983он. -442х.	T-14801-14802
8-р боть: 1984-1986он. -312х.	T-14803-14804
9-р боть: 1987-1989он. -345х.	T-14805-14806
10-р боть: 1988-1989он. -282х.	T-14807-14808

Осор Б., Дамдинсүрэн Б. **Үлэмж тансаг говь мину, Үүлэн цэнхэр Алтай мину** /Ред. Н.Жанчивдорж, Т.Билэгт. –УБ.: Мөнхийн үсэг, 2010. -618х.

Говь-Алтай аймгийн уугуул иргэд Б. Осор., Б. Дамдинсүрэн нарын толилуулж буй энэ номонд Говь-Алтай аймгийн эрт эдүгээгийн түүх, аймгийн нам, төр захиргаа, аж ахуй соёлын байгууллагууд, алдар нэрээ дуурсгасан алдартан сэхээтэнүүд, байгаль, ан амьтан, ургамал, ашигт малтмал, түүхийн дурсгалт газрууд, сумдын танилцуулгын тухай өгүүлнэ.



63.3/1-M5/

O-52

T-14844-14846



Очир А. **Монголын түүхийн судалгаа: 1-3 боть** /Ред. С.Чулуун. –УБ.: Соёбо принтинг, 2011.

Түүхийн шинжлэх ухааны доктор, профессор А.Очир түүхийн янз бүрийн үеүдэд өөрийн бичсэн монголын түүхэнд холбогдох өгүүлэл, эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэл, хамтын бүтээлд бичсэн бүлэг зүйлүүдээ 3 ботид эмхэтгэн, монголын түүх судлаач нийт уншигчдад толилуулж байна. 1-р ботид эртний судлал, бичээсзүйн бүтээлүүд, 2-р ботид түүхийн судлалын бүтээлүүд, 3-р ботид угсаатны судлал, нэр зүйн бүтээлүүд тус тус оржээ.

63.3/1/

/НХШУН унш-7ш/

O-60

1-р боть: Эртний судлал, бичээсзүй. -392х.

T-14775-14777

2-р боть: Түүхийн судлалын бүтээл. -394х.

T-14778-14780

3-р боть: Угсаатны судлал, нэр зүйн бүтээл. -400х.

T-14781-14783

Тувагийн түүхэнд холбогдох архивын баримтын эмхэтгэл: Боть 1. –УБ.: Адмон, 2011. -498х.

Энэхүү толилуулж буй “Тувагийн түүхэнд холбогдох архивын баримтын эмхэтгэл”-д Тувагийн түүхэнд холбогдох Тагна урианхай, Алтайн урианхайн баримтууд багтсан бөгөөд Манжийн тэнгэр тэтгэсэн хааны 3-р он буюу 1738 оноос эхлэн Хэвт ёсны 3-р он буюу 1911 он хүртэлх нийт 189 баримт багтжээ. Энэ ном нь он удаан жил үргэлжилж буй Тува-Монголын харилцааны түүхийг судлаач нийт уншигчдад зориулагджээ.

63.2/Орос-Тув/

T-63

/НХШУН унш-3ш/

T-14759-14760



Түүхийн судлал: БотьXL: 1-17р дэвтэр. УБ.: Мөнхийн үсэг, 2010. -390х.

ШУА-ийн түүхийн хүрээлэнгээс эрхлэн гаргадаг энэхүү “Түүхийн судлал” бүтээлд Хүннү, Атилда, Юан улс, Монголын шинэ үеийн түүх, Их монгол ба Багдад, Далай лам, Халхын Түшээт хан, Бодоогийн хэрэг, Тайсун хаан, Монгол улсын тогтвортой хөгжил, шинэ эргэлтийн бодлого, атрын анхны аяны тухай судалгааны өгүүллүүд оржээ.

63.3/1/

T-82

/НХШУН унш-3ш/

T-14771-14772

Хишигт Н. **Монголын хувьсгал 1921**: Монголын үндэсний ардчилсан хувьсгалын түүхийг нэхэн дурсахуй /Хян. Ч.Дашдаваа. –УБ.: Бемби сан, 2011. -299х.

Энэхүү бүтээлд 1920-1921 онд Монгол оронд өрнөсөн түүхэн үйл явдлуудыг нэхэн судалж, үндэс угсаагаа хамгаалан боссон эх орончдын үйл хэргийг дэлгэрэнгүй өгүүлэн, харийн эзэрхэгчүүдийг эх нутгаасаа хөөн зайлуулж, эрх чөлөөгөө олсон ард олны тэмцлийн өрнөл, ялалтыг харуулан, үр дүн ач холбогдлыг дүгнэжээ. Уг бүтээл нь орчин үеийн Монголын түүхийг сонирхон судлагч түүхчид, улс төр ба намтар судлалаар судалгаа хийж буй нийт уншигчдад зориулагджээ.



63.3/1/61

X-37

/НХШУН унш-3ш/

T-14787-14788



Шинээр олдсон халхын дөрвөн аймгийн ноёдын хүрдэн зураг. /Галигласан С.Чулуун, Н.Хатанбаатар. –УБ.: Адмон, 2011. -296х. /Түүхийн дурсгалт бичиг: 8-р боть/

ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “Monumenta historica” цувралын энэхүү 8-р ботид Хөвсгөл аймгийн орон нутгийг судлах музейн фондноос олдсон халхын бүх ноёдын гэрийн үеийн бичмэлийг галиглан, тайлбар бичиж түүх судлаач нарт толилуулж байна.

63.3/1/

Ш-66

/НХШУН унш-2ш/

T-14773-14774

ЭДИЙН ЗАСАГ

Баярдаваа Б. Гансүлд Д. **Эдийн засгийн онол**: 2 дахь хэвлэл. – УБ.: 2006. – 458 хууд.

“Эдийн засаг онол” номонд эдийн засгийн онолд өргөн ашиглагддаг үндсэн онол, зарчмууд, эдийн засгийн бусад ойлголт, хувьсагчдын хоорондын хамаарлыг график болон томъёо, функц ашиглах замаар эдийн засгийн тайлбарыг энгийнээр нарийвчлан сэдэвт холбоотойгоор тооцоолон бодох жишээ бодлогыг бодож тайлбар хийжээ. Энэхүү номыг СЭЗДС-ийн эчнээ, оройн хөтөлбөртэй уялдуулан, эдийн засгийн онолын анхан шатны ойлголт авахыг зорьж буй хүмүүс болон эхлэн судлагсад зориулан гаргажээ.



65.011я73

Б-38

/НХШУН унш-25ш/

Б-20897-20901



Дагвасүрэн Д. **Яаж баян болох вэ? буюу санхүүгийн цагаан толгойд тайлагдах нь** /Хян. Д.Энхжаргал, Д.Азжаргал. –Чойбалсан.: 2010. -88х.

Яаж баян болох тухай алтан 17 гол дүрэм, амжилтанд хүрч, баяжих арга ухааны 15 нууц, баян чинээлэгийн 5 чухал хуулийн тухай энэ номонд өгүүлнэ. Хэрэв та хараахан баян болж чадаагүй мөн баян болохыг хүсч байвал энэ номыг заавал уншаарай.

65

Д-15

Б-20941-20942

Киесо Д. Е. **Дунд шатны нягтлан бодох бүртгэл**: 2 дахь хэвлэл. –УБ.: Экимто, 2011. -780х.

Энэхүү сурах бичиг нь АНУ төдийгүй дэлхийн олон оронд нэрд гарсан бүтээл билээ. Онол арга зүйн өндөр түвшинд боловсруулагдсан, тусгай сэдвүүдийг сүүлийн үеийн чухал мэдээллээр баяжуулсан, бүлэг бүрийн ард практик шинжтэй өвөрмөц хавсралт тооцоог агуулснаараа бусад сурах бичгээс онцлог юм.

65.052

К-38

/НХШУН унш-55ш/

Т-14747-14751



Маршалл А. **Эдийн засгийн ухааны зарчмууд** /Орч. Ч. Энхмаа, Ред. Ц. Батбаатар. – УБ.: Монсудар, 2011. – 270 хууд.

Эдийн засгийн сонгодог бүтээлүүдийн нэг А. Маршаллын энэ ном монгол хэлнээ орчуулагдан гарч байгаа нь зах зээлийн харилцаанд шилжиж буй манай орны иргэдийн эдийн засгийн ерөнхий хөгжил боловсролын түвшинг дээшлүүлэхэд чухал нөлөө үзүүлэх болно. Түүний энэ бүтээл эдийн засгийн ерөнхий агуулгаараа төдийгүй математик үндэслэлүүдээрээ агуу бүтээл болж чаджээ.

65.011

М-28

/НХШУН унш-2ш/

Б-20969-20970



Стиглиц Жозеф Е. **Дэлхийчлэл ба түүний сэтгэлд эс нийцэх нь** /Анг. хэл. Орч. Д. Чулуундорж. – УБ.: Адмон, 368 хууд.

Жозеф Е. Стиглицын энэ номд дэлхийн олон оронд өнөө үед тулгарч буй эдийн засгийн тулгамдсан асуудлууд тухайлбал: хөрөнгийн зах зээлийн чөлөөлөлт, зах зээлд шилжих үйл явц, өмч хувьчлал, чөлөөт худалдаа болон хөрөнгө оруулалтын асуудал зэргийг тусгасан ба зах зээлд хийх шилжилтийн нарийн төвөгтэй асуудлуудыг улс орнууд хэрхэн шийдвэрлэсэн тухай, “Цочролын эмчилгээ”, түргэн хувьчлалын замыг сонгосон Орос улс зэргийн туршлага, аль эсвэл аажим шилжилт хийж амжилт олсон Хятад, Тайваны туршлагын тухайг ч бас өгүүлэх аж.

65.5

С-67

/НХШУН унш-7ш/

Б-20989-20991



Уэтглэс Уоллис Д. **Баян болох нууц**. – УБ.: Битпресс, 2010. – 118 хууд.

Тус ном нь философи болон онол дээр үндэслэгдээгүй зөвхөн амьдралын практик дээр суурилсан ажээ. Баян болохыг хүссэн хэнд ч, мөнгө тэдний хамгийн их тулгамдсан хэрэгцээ болсон тэр л хүмүүст зориулагдана. Хэрэв та үүний үр шимийг хэрэгжүүлбэ гэвэл энэ номыг уншаад яг энд хий гэснийг л хийгээрэй.

65

У-43

/НХШУН унш-7ш/

Б-20948-20950



УЛС ТӨР СУДЛАЛ

Баянжаргал Ч. **Улс төрийн хариуцлага**. –УБ.: 2011. -34х.

Монголын нийгэм-улс төрийн удирдлагын хариуцлагагүй байдал, түүний арга хэрэгсэлийн өгөөжгүй бүдүүлэг шинж нь манай улс төрийн сэтгэлгээнд үлэмж хоосон зай байгааг харуулж байна. Энэ тухай баримтад тулгуурласан энэхүү бяцхан ном нь улс төрийн хариуцлага, эс хариуцлагын талаар уншигч таньд өгүүлэх болно.



66.0
Б-38

/НХШУН унш-3ш/

Б-20913-20914



Болдбаатар Ж, Батбаяр Ц. **Монгол, Хятадын харилцааны түүхийн зарим асуудал** /Ж. Болдбаатар, Ж. Урангуа. – УБ.: Никель-Дикель, 2011. – 196 хууд.

Тус ном нь 3 бүлэгтэй. Эхний 1-р бүлэгт: Хятадын хувьсгалт хөдөлгөөний талаарх МАН-ын байр суурь /1921-1924/, 2-р бүлэгт: МАХН, ХКН болон бусад улс төрийн хүчинтэй харилцаагаа хөгжүүлсэн нь /1925-1930/, 3-р бүлэгтээ: Олон улсын байдлын ээдрээтэй нөхцөл дэх БНМАУ ба Дундад Иргэн Улс /1931-1949/-ын тухай авч үзжээ.

66.4/1/
Б-54

/НХШУН унш-3ш/

Б-20797-20798

ХБНГУ ба МУ-ын хооронд байгуулагдсан гэрээ, хэлэлцээрүүд: 2 дахь хэвлэл. – УБ.: 2008. – 394 хууд.

Манай хоёр улс нь 1995, 2008 оны хамтарсан тунхаглалуудын үзэл санаанд тусгагдсан иж бүрэн түншлэлийн харилцааг хөгжүүлсээр ирсэн. Энэхүү номыг анх 2005 онд хэвлүүлэхдээ хоёр талын гэрээ, хэлэлцээрүүдийг оруулж байсан бол энэ удаа түнш хоёр орны хамтын ажиллагааны стратегийн чиг баримжааг тодорхойлж буй 1995, 2008 оны хамтарсан тунхаглалуудын бусад баримт бичгүүдийн хамт баяжуулалт хийн нэмж оруулжээ.



66.4/4Гер/
Х-42

T-14741

ХУУЛЬ ЗҮЙ



Баярсайхан Б., Батбаяр Б., Лхагважав Б. **Монголын шүүн таслах ажиллагааны түүхэн сурвалж бичигт хийсэн шинжилгээ.** /Улаан хацарт/ -УБ.: Адмон, 2010. - 510х.

“Улаан хацарт” хэмээх эх сурвалж нь Их шавийн яамнаас хэрэг шийтгэсэн хуулга данс ажээ. Улаан хацарт-д Манжийн төр гэрэлт, Түгээмэл элбэгт, Бүрэнт засагч, Бадаргуулт төр, хэвт ёс хааны он тооллоос гадна Хаант монголын олноо өргөгдсөн он тооллыг тус тус тэмдэглэсэн нь уг хэрэг шийтгэсэн дансыг 1913 оноос, эсвэл 1821 оноос эхэлж 1913 онд сүүлийн хэргийг данслан бүртгэжээ. Зохиогчид энэ удаад үндэсний номын санд хадгалж буй “Шавь яамны улаан хацартаас хуулсан дүрэм”-ийн хуулбар буюу Халх журмын эхүүдийг галиг үсэгт хөрвүүлж, бүх үгийн хэлхээсийг үйлдэж, зарим үгийн тайлбартайгаар уншигчдад толилуулж байна.

67.3/1/
Б-38

/НХШУН унш-3ш/

T-14825-14826

Болдбаатар Ж, Лүндээжанцан Д. **Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал:** Нэмж засварласан 2 дахь хэвлэл /Хян. И. Дашням. – УБ.: Соёмбо принтинг, 2011. – 508 хууд.

Энэхүү 2 дахь удаагийн нэмж засварласан хэвлэлдээ төр, эрх зүйн түүхийн шинжлэх ухааны сүүлийн үеийн ололтуудыг нэмэн тусгаж, шинэ баримт сэлтүүд, агуулгаар нь баяжуулалт хийжээ.

67.99/1/0
Б-54

/НХШУН унш-3ш/

Б-20801-20803





Жанцан С. **Монгол улсын эрүүгийн эрх зүйн онол.** 1-р боть: Гэмт хэргийн тухай сургаал. –УБ.: ХЗҮХ хэвлэх үйлдвэр, 2009. -966х.

Энэ номонд эрүүгийн эрх зүйн эх сурвалж, түүний түүхэн уламжлал, Монголын төрийн эрүүгийн бодлого, шинэчлэл, гэмт хэргийн ойлголт түүний үндсэн шинж, эрүүгийн хариуцлага, ялын сургаал, гадаадын зарим орны эрүүгийн эрх зүйн онцлог, эрүүгийн эрх зүйн онолын сэтгэлгээ, үзэл баримтлалыг иж бүрнээр тусгажээ.

67.408/1/

Ж-28

/НХШУН унш-3ш/

Т-14823-14824

Монгол улсын хууль тогтоомжийн түүхэн товчоо: 1911-2011 /Б.Баярсайхан, Б.Батбаяр ба бус. -2 дахь хэвлэл. –УБ.: 2011. -1022х.


Энэхүү “Монгол улсын хууль тогтоомжийн түүхэн товчоо”-нд Монгол улсын хууль тогтоомжийг 1911-2011 он хүртэл он дарааллаар жагсаан тухайн эрх зүйн актын нэр, баталсан эрх бүхий этгээдийн нэр, товч агуулгыг дурджээ. Мөн энэхүү судалгаанд Монгол улсын 100 гаруй жилийн хууль тогтоомжийг эх сурвалжийн түвшинд, заримыг товч лавлагаа байдлаар оруулахдаа анхны хэвлэлд орхигдсон эх сурвалж, хууль тогтоомжийг нэмж оруулжээ.

67.400.1

М-69

/НХШУН унш-2ш/

Т-14757-14758



Нарангэрэл С. **Эрх зүйн эх толь бичиг:** 3 дахь хэвлэл. –УБ.: Адмон, 2011. -699х.

Энэхүү толь бичигт эрх зүйн шинжлэх ухаан, олон улсын ба гадаад улсуудын эрх зүйн үндсэн салбар, түүнчлэн төр, эрх зүй, түүх, криминологи, криминалистик, шүүх эмнэлэг зэрэг хууль зүйн практикт буй голлох суурь болсон 8000 гаруй нэр томъёо ба хэллэгийн тайлбарыг оруулж, латин, англи, орос хэлээр дүйцүүлэн хийжээ. Энэ толь бичиг нь их дээд сургуулийн оюутан, магистрант, эрдэм

шинжилгээний ажилтан, хууль тогтоогчид, хууль сахиулах байгууллагын ажилтан нарт зориулагджээ.

67я2

Н-29

/НХШУН унш-3ш/

Т-14821-14822

СОЁЛ СУДЛАЛ

Гуревич П.С. **Соёлын философи: Философи-түүхийн анализ: Сурах бичиг- I. II.** /Орч. Ц. Алтантуяа, Н. Энхцогт. – УБ.: Удам соёл, 2011.

Соёл судлал, соёлын философи, соёл ба соёл иргэншлийн тухай асуудал өнөөдөр дэлхийн олон эрдэмтдийн анхаарлыг татсан асуудал болоод байгаа ба энэ талын судалгаа ч ихээр хийгдэх болсон. Эдгээр эрдэмтэн судлаачдын дотроос Оросын соёл судлаач эрдэмтэн П.С.Гуревич доривтой бүтээлүүд бичсэн билээ. Энэ хүн зөвхөн соёл судлал төдийгүй мөн соёлын философи,соёл иргэншлийн асуудлаар ч олны анхаарал татсан судалгаа хийжээ. Иймд энэ удаа түүний “Соёлын философи” хэмээх нэгэн суурь бүтээл орчуулсныг нь оюутан, залуус, уншигч, судлаач та бүхэнд толилуулж байна.

71.0я73

/НХШУН унш-7ш/

1-р дэв. – 154 хууд.

Б-20905-20907

Г-95

2-р дэв. – 159 хууд.

Б-20908-20910





Долгорсүрэн Ж. **Соёлын бодлого**: Соёл, урлагийн салбарын хувьчлал /Ред. Б.Баяртөр. –УБ.: Урлах эрдэм, 2010. -192х.

Энэхүү судалгааны материалын эхний хэсэгт монголын төр олон нийтийн зүгээс соёлыг ойлгож, соёлд хандах хандлага, ардчилсан төрөөс соёлын талаар явуулж ирсэн бодлогын онцлог, түүний хэрэгжилт, дараагийн хэсэгт Монголын соёл, урлагийн салбарт нэвтэрч буй өмчийн олон хэлбэр, хувьчлалын үйл явц, түүний үр дүнг өгүүлэх ба АНУ, Нидерланд, Франц, Герман, Швед, Герман, Голланд, Чех, Польш зэрэг Европын орнуудад соёл, урлагийн салбарт хийсэн хувьчлалын туршлага түүнээс суралцах боломж зэрэгт үнэлэлт өгч, дүгнэлт гаргажээ.

71.4/1/

Д-46

/НХШУН унш-3ш/

Т-14761-14762

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Жадамбаа Б., Чимэдлхам Ц. **Судалгааны арга зүй**: 2 дахь хэвлэл. –УБ.: 2011. - 303х.


Магистрант, докторант, судлаач нарт зориулагдсан энэхүү номонд судлаач бүрийн зайлшгүй мэдвэл зохих шинжлэх ухааны танин мэдэхүйн болон судалгааны талаарх ойлголт, тэдгээрийн бүтэцчилсэн хүрээ, түүний бүрдүүлбэр, судалгааны асуудлыг тодруулан оновчлох, судалгааны арга зүй, бүтэц зохион байгуулалт, математик статистик ба түүвэр, хувьсагчийг хэмжих, тоон ба чанарын баримт цуглуулах аргууд, цуглуулсан баримтанд задлан шинжижиглээ, дүгнэлт хийх арга зүй, тэдгээрийг шинэчлэх чиглэл зэргийг тодорхой тусгаж өгчээ.

72

Ж-12

/НХШУН унш-10, БШУН унш-5ш/

Т-14742-14746



Монгол судлалын чуулган: Эрдэм шинжилгээний сэтгүүл: Боть №11/46/. –УБ.: 2011. -263х.

МУБИС-ийн Монгол Судлалын Сургуулиас эрхлэн гаргасан энэхүү эрдэм шинжилгээний бүтээлд монгол хэл, эх бичвэр, монголын утга зохиол, харьцуулсан уран зохиол, баатарлаг туульс, хөрөг дүрслэл, сэтгүүл зүй, уран бичлэг, шог хошин зохиолын тухай өгүүллүүд оржээ.

72

М-69

/Лав.ф-1ш/

Б-20895

МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг: Физик. №355/16/. –УБ.: 2001. -141х.

МУИС-ийн ФЭС-иас эрхлэн гаргасан эрдэм шинжилгээний бичгийн энэ дугаарт потенциал орон дахь бөөм, дулааны боловсруулалтанд оруулсан нүүрсний ЭПР, олон ханатай нүүрстөрөгч, давхар вольфрамит, дейтрон, нейтрон, усны геофизик, нарны цацрагийн энерги, агаар мандлын оптик, гэрлийн туйлшралтай холбогдолтой судалгааны өгүүллүүд оржээ.

72

М-69

/БШУН унш-2, Лав-1ш/

Т-14814-14815



Эрдэм шинжилгээний бичиг: 2010-2011 оны ЭЗС-ийн эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл /Ред. А. Солонго, Ц. Цолмон, Л. Нарандалай. – УБ.: 2011. – 263 хууд.

МУИС-ийн ЭЗС-аас 2010-2011 оны хичээлд зохион байгуулсан оюутны эрдэм шинжилгээний хуралд түрүүлсэн оюутнуудын эрдэм шинжилгээний ажлын эмхтгэлийг уншигч та бүгдэд хүргэж байна.

72

Э-73

/НХШУН унш-2ш, Лав-1ш/

Б-20995

ХЭЛ ШИНЖЛЭЛ

Англи хэлний анхан шатний сонсох дадал-1: Англи хэлээр зөв уншиж, сонсож, ойлгож, орчуулж сурцгаая: Эхлэн суралцагчдад зориулав /Эмх. Д. Үнэнбат, Л. Дорждэрэм. – УБ.: Урлах эрдэм, 2010. – 102 хууд.



Эхлэн суралцах гэж байгаа хүмүүс юуны түрүүнд тухайн хэлээр зөв дуудаж, уншиж, сонсож, орчуулж сурахад нь энэхүү ном таны дотны туслагч болж өгнө. Энэхүү CD-тэй номыг англи хэл эхлэн суралцагчид нь компьютер, машин, аудио хөгжимд хэрэглэж болохын зэрэгцээ MP 3; IPKD; гар утсандаа суулгаж хаана ч сонсож хэрэглэх бололцоотой хувилбараар бичжээ.

81.2Анг

А-61

/НХШУН унш-12ш/

Б-20807-20809



Болдбаатар Д. **Хятад-Монгол, Монгол-Хятад толь:** Анхдугаар хэвлэл /Хян. Б.Билгүүн, С.Бат-Эрдэнэ. – УБ.: Соёмбо принтинг, 2011. – 314 хууд.

Энэхүү толийг хэрэглэгчдийн хүсэлтээр авч явахад боломжийн жижиг хувилбараар гадаад хэлний сургалт, ажил хэргийн хэрэгцээг бүрэн хангахуйц энэ шинэ толио та бүхний гарт өргөн барьж байна.

81.2Хят-4

Б-54

/НХШУН унш-15ш/

Б-20866-20870

Болдбаатар Д. **Хятад-монгол толь бичиг.** –УБ.: Соёмбо принтинг, 2011. -609х.

2004 онд хэвлэгдэн гарсан өмнөх толь бичгээс энэхүү толь бичиг нь гадаад хэлний сургалт, ажил хэргийн хэрэгцээг хангахуйц, авч явахад авсаархан болсноороо ялгаатай ба Хятад хэл сурч буй нийт уншигчдад зориулагджээ.


81.2Хят-4

Б-54

/НХШУН унш-15ш/

Б-20861-

20865



Герман – монгол толь бичиг /Ред. Б.Баярсайхан. –УБ.: Монсудар, 2008. -749х.

Энэхүү толь бичиг нь өргөн хэрэглээний, түүний дотор зах зээлийн эдийн засаг, санхүү бизнес, мэдээлэл, холбоо, интернет, компьютерийн шинэ нэр томъёог багтаасан 65 000 гаруй толгой үг, хэллэгтэй бөгөөд мөн улс орон, хүн ам, соёлын талаарх товч танилцуулга, үйл үгийн хүснэгт, герман хэлний товч дүрмүүдийг агуулжээ.

81.2Гер-4

Г-39

/НХШУН унш-7ш/

Т-14719-14721

Герман-монгол, монгол-герман өврийн толь /Ред. Б.Баярсайхан. –УБ.: 2009. – 1102х.

Монсудар ба ХБНГУ-ын хэвлэлийн газартай хатран гаргасан энэхүү толь бичигт идэвхтэй хэрэглэгддэг 35 000 үг орсон ба герман, монгол хэл сурч буй хүмүүст зориулагджээ.

81.2Гер-4

Г-39

/НХШУН унш-3ш/

Б-20855 -20857



Герман хэлний сурах бичиг. – УБ.: Адмон, 2008.

Герман хэлний энэхүү сурах бичиг нь их, дээд, сургуульд суралцагч оюутан залуучууд болон насанд хүрэгчдэд зориулсан нийт 3 цуврал сурах бичигтэй, дасгалын 2 номтой юм. Уг цуврал нь европын орнуудад мөрдөгддөг хэлний А1, А2, В1 түвшинд нийцсэн 2006 оны герман хэлний шинэ зөв бичгийн дүрмийн дагуу зохиожээ. Энэ цуврал нь хичээлийн, дасгалын, сонсох, багшийн, үгсийн сангийн эмхтгэл, Online материал гэсэн хэсгүүдээс бүрдсэн байна. Герман хэл сурах хүсэл эрмэлзлэлтэй залуустаа энэхүү иж бүрэн сурах бичгийг өргөн толилуулж байна.

81.2Гер-923

/НХШУН унш-7ш/

Г-39

Сурах бичиг-1. -78х.

T-14725-14727

Сурах бичиг-2. -206х.

T-14728-14730

Сурах бичиг-3. -214х.

T-14734-14736

Дасгалын ном-2.– 108 хууд.

T-14731-14733

Дасгалын ном-3.– 100 хууд.

T-14737-14739

Дашдондов Ц, Наранхүү Х. **Англи хэлний ижил үгийн анхны шинэ тайлбар толь** /Хян. Б. Батцэцэг. – УБ.: мөнхийн үсэг, 416 хууд.

81.2Анг-4

Д-39

НХШУН унш-7ш/

Б-20929-

20931



Латин-Монгол, Монгол-Латин тайлбар толь:

Өвөрмөц хэлц хэллэг: Онч мэргэн онцлог үг хэллэг: Зүйр цэцэн үгс: Сургаал үгс. – УБ.: 2003. – 250 хууд.

Энэ толь нь латин үсэг, латин хэл, соёл дэлгэрэхэд тус дэм үзүүлэх зорилготой ажээ. Энэхүү хэлцийн толь нь латинчлагдах, латин үг хэллэгийг зохиол бүтээлдээ хэрэглэх, тэр эртний онч мэргэн үгсийн онцгой утга учраар оюун ухаанаа тэлэхэд тань тус болох байх. Учир нь аль ч хэлнээ хэлц үг нь сонин зүйрлэл, уран дүрслэл, найруулгын гайхалтай өнгө аяс хүний сэтгэлийн гүнд хүрэх чадлаар онцгой гэдгийг энэ нэгэн толиос мэдэх болно. Хэлц үгийн олон утгыг гаргасан энэ толь дуун хөрвүүлэгч, эрдэмтэн судлаач, толь зүйч нарт шинжилгээ судалгааны чухал хэрэглэгдэхүүн болж өгнө.

81.2Лат-4

Д-39

/НХШУН унш-7ш/

Б-20932-20934

Дашдондов Ц. **Нэрийн англи зохист дуудлагын толь:**Тайлбар тодруулгатай /Хян. Б. Ганболд. – УБ.: Мөнхийн үсэг, 176 хууд.

Гадаад хэл нь зөвхөн харилцааны хэрэглүүр болох төдийгүй тухайн хүний мэдлэг боловсрол, соёлын хэмжээний илэрхийлэл болж байдаг билээ. Уг лавлах толь нь “Хүн зоны нэр”, “Улс орон, уул ус, хот нийслэлийн нэр,” гэсэн 2 хэсгээс



бүрдэж байгаа. Ямар, ямар нэрийг яаж хэрхэн зөвөөр дуудахыг нь галгиласан болно. Гэхдээ дэлхий даяарт даган мөрддөг авиа галигчлах үсэг IPA буюу international phonetic Alphabet хэргэлсэн. Энэ үг нь зөв хэлж дуудах түлхүүр /Pronunciation/ key/ юм. Тийм учраас хэлийг аль болохоор зөв эзэмших, цэвэр дуудах, ялангуяа хүн зон, улс орон, хот суурин, уул усны нэр, нийтээр өргөн хэрэглэдэг нэр томъёо зэргийг дуудснаар наандаж хялбар ойлголцох, цаандаж мэдлэг боловсролын түвшингээ харуулахад тань тустай. Иймд манай нэрт сэтгүүлч, толь-зүйч Ц. Дашдондовын толийг хэрэглэгч таны гар дээр өргөн барьж байна.

81.2Анг-4

Д-39

/НХШУН унш-7ш/

Б-20923-20925



Дашдондов Ц. **Харь хэлний хатуу самар цөмөгчдөд**: Өрнийн онигоо хадмал орчуулгатай: Өвөрмөц хэллэг харьцуулах эквиваленттай: Хорвоод хосгүй монгол гурвал англиар: Хотлоор дээдлэх латин хэллэг монголоор /Орч. Ред. С. Бямбаням, Хян. Б. Чулуундорж. - УБ.: Мөнхийн үсэг, 220 хууд

81.2

Д-39

/НХШУН унш-7ш/

Б-20926-20928


Дашдондов Ц. **Хос хэлний ном**: Харь хэл сурья гэвэл харьцуулж унш /Орч. Ред. Батцэцэг Б, Хян. Ц. Жаргалсайхан, Т. Доржсүрэн. – УБ.: Мөнхийн үсэг, 200 хууд.

81.2

Д-39

/НХШУН унш-7ш/

Б-20935-20937



Даррел И. **Интернэтийн тайлбар толь** /Орч. Ц.Энхмаа, С.Лодойсамба, И.Цэрэнололт. –УБ.: Монсудар, 2008. -432х.

Өнөө цагт асар хурдацтай өсөн нэмэгдэж буй интернэтийн хэрэглээг даган интернэтийн орчинд компьютер техникийн шинэ нэр томъёоны мянга мянган шинэ үг хэллэг монгол хэлэнд орж ирж байгаа билээ. Тэрхүү шинэ нэр томъёонуудыг ойлгомжтой байдлаар тайлбарласан, 4000 орчим нэр томъёог багтаасан энэхүү толь бичгийг англи хэл судлаач мөн компьютерийн чиглэлээр

сурч буй оюутнууд, нийт уншигчдад зориулжээ.

81.2Англ-4

Д-32

/БШУН унш-15ш/

Б-20189-20203


Дорждэрэм Л. **Франц-монгол харилцан ярианы сурах бичиг-1.** –УБ.: Урлах эрдэм, 2007. -222х.


Франц хэл сурах хүсэл эрмэлзэлтэй хүмүүст зориулсан энэ номонд өдөр тутмын хэрэглээний төрөл бүрийн сэдвээр франц хэлээр хэрхэн ярилцах, харилцан ойлголцох зэргийг харилцан ярианы хэлбэрээр оруулж өгчээ. Үүнд 44 сэдэв бүхий нийт 164 харилцан яриаг оруулжээ.

81.2Фр

Д-54

Б-20813-20814





Дорждэрэм Л. **Франц хэлний энгийн ярианы үг хэллэгийн толь.** –УБ.: Урлах эрдэм, 2008. -248х.

Энэхүү франц хэлний энгийн ярианы үг хэллэгийн толинд франц хэлэнд маш түгээмэл хэрэглэгддэг үг, хэллэгийг түүвэрлэн авсан ба тэдгээрийг франц хэлний уран зохиолын болон энгийн хар ярианы жишээгээр оруулсан ба үг хэллэг тус бүрт оноосон жишээ оруулжээ.


81.2Фр-4
Д-54

/НХШУН унш-7ш/

Б-20818-20820

Нарантуяа Ч. **Бийрийн уран бичлэг** /Ред. М.Алтанцэцэг. –УБ.: Монгол судлал, 2011. -50х.

Зохиогч Нарантуяа Монголын эртний бийр бэхийн урлаг, уран бичлэг-каллиграф хэмээх урлагийн бичлэгийн хэлбэрүүдээс уг эхээр нь цуглуулснаа эмхэтгэн уран бичлэгийн урлагийг сонирхон судалж, бийрээр бичиж эхэлж байгаа уншигч, урлагийн сургуулийн оюутнуудад толилуулж байна.



81.2-8
Н-29

/НХШУН унш-3ш/

Б-20911-20912



Поппе Н.Н. **Монгольский словарь "Мукадимат Ал-Адаб": I-II** /Ред. В. В. Струве. - М.: Наук, - 451 хууд.

Монгол орны талаар гадаад дотоодын эрдэмтэд олон зууны туршид туурвисан бүтээлүүд нь дэлхийн монгол судлалын сан хөмрөгийг бий болгосон байдаг. Энэ удаад “Монголч эрдэмтдийн бүтээлийн дээжис” цувралын тэргүүн ботид нэрт монголч эрдэмтэн Н.Н.Поппегийн эмхэтгэн найруулж 1939 онд хэвлүүлсэн монгол хэлний толь бичгийн түүхэн эх сурвалжийн нэг болох “Монгольский словарь Мукадимат Ал-Адаб”-ын толь бичгийг сонгон та бүхний хүртгээл болгож байна.

81.2Мон-4
П-57

/НХШУН унш-7ш/

Б-10158-10160

Пүрэв-очир Б. **Үг, өгүүлбэрийн амь, амьдрал, эрчим долгион, соёл хэрэглээ.** – УБ.: Мөнхийн үсэг, 2011. -307х.

Энэхүү бүтээлд хэлшинжлэл, утга зохиол шинжлэлийн онол-аргазүйг зохистой харьцаанд зэрэгцүүлэн тавьж, үг өгүүлбэрийн амь амьдрал, эрчим долгион, соёл хэрэглээг судалснаараа уран сайхны эхийн задлал буюу уран зохиолын туурвилзүйн онцлогийг бодитой нээн харуулжээ.



81.2М-2
П-91

/НХШУН унш-3ш/

Б-20795-20796



Түгээмэл хэрэглээний 1000 үгийн толь бичиг: Англи-монгол /Эмх. Б.Бадамханд. –УБ.: Монсудар, 2010. -159х.

Хамгийн чухал мянган үгийн энэхүү толь бичигт хамгийн их хэрэглэгддэг англи үг болон өгүүлбэрийг эмхэтгэн оруулсан бөгөөд жишээ өгүүлбэрүүд нь тухайн үгийг хэрэглээнд хэрхэн хэрэглэдгийг харуулах болно. Англи үгийн дуудлагыг оруулсан энэхүү тол бичиг нь дунд сургуулийн 3-р ангийн сурагчдаас дээш насны бүх хүмүүсийн англи хэлний анхан шатны мэдлэгт зориулагджээ.

81.2Англ-4
Т-74

/БШУН унш-5, НХШУН унш-10ш/

Б-20850-20854

Уранбилэг Б. **Англи хэлийг монгол хэлээр. Let's talk with To-be...Тү-Би-гээр ярьж сурцгаая.** –УБ.: Адмон, 2010. -190х.

Англи хэлний цөм болсон To-be үйл үгээр хэрхэн олон санааг гаргаж болдогийг, мөн эх хэл, эх орныхоо сайн сайхныг таньж мэдэх, монголынхоо гайхамшигтай үзэсгэлэнт газраар аялах, хөтөч тайлбарлагчаар ажиллахад анхаарах зүйлүүдийн талаар дэлгэрэнгүй тайлбарлажээ.

81.2Англ

У-45

/НХШУН унш-25ш/

Б-20876-20880



Уранбилэг Б. **Багшгүйгээр англи хэл сурцгаая.** –УБ.: 2009. -160х.

Англи хэл сурахыг хүссэн бүх насны хүмүүст зориулагдсан энэхүү ном нь англи хэлний биеийн, хамаатуулах, асуух, төлөөний үгүүдийг монгол дуудлагын хамт, мөн авиа зүйн дуудлага, хэл зүйн дүрмүүдийг илүү дэлгэрэнгүйгээр тайлбарласан 200 орчим цагийн хичээлийг багтаажээ.

81.2Англ

У-45

/НХШУН унш-25ш/

Б-20871-20875

Үнэнбат Д. **Англи хэлний сонсох ном.** –УБ.: 2011. -127х. /CD-тэй/

Англи хэлийг эхлэн суралцаж буй хүмүүст зориулсан энэхүү сонсох ном нь Clare Harris 'The umbrella', Stephen Colbourn 'The lost ship', Stephen Rabley 'Marcel and the white star', Mitchell H.Q. 'Paul and Pierre an Paris' гэсэн 4 өгүүллээс бүрдэх ажээ.

81.2Англ

Ү-84

/НХШУН унш-12ш/

Б-20804-20806



Үнэнбат Д. **Япон хэлний цагаан толгой: Хирагана, катакана.** –УБ.: 2011. -152х.

Япон хэлийг анхлан суралцагч хүүхэд залуус, оюутан сурагчдад зориулагдсан энэ ном нь 2 бүлгээс бүрдэх ба япон хэлний хирагана катакана цагаан толгойн үсэг тус бүрт нь тухайн үсгийн үүсэл гаралыг үзүүлсэн зураг, үсгийн зурлага, үсгийг бичих дадал олгох хүснэгт, мөн дасгалыг хариутай нь багтаажээ.

81.2Яп

Ү-84

/НХШУН унш-12ш/

Б-20810-20812

Франц хэлний сонсох дадал: Анхан шат /Эмх. Л.Дорждэрэм. –УБ.: 2011. -172х. /CD-тэй/


Франц хэлийг эхлэн сурч буй хүмүүст зориулсан энэхүү ном нь нийт богино хэмжээний 29 сэдэв, францын алдарт зохиолч Ги де Мопассаны “Гоёлын зүүлт” өгүүллийн хялбаршуулсан хувилбараас бүрджээ.

81.2Фр

Ф-84

/НХШУН унш-7ш/

Б-20815-20817



Чамберс **Оюутан сурагчийн англи хэлний тайлбар толь бичиг:** Дунд шатны суралцагчдад зориулав. – Монсудар, 2009. – 811 хууд.

Шинжлэх ухаан, математик, мэдээллийн технологи зэрэг бүх хичээлийн сэдвүүдэд хэрэглэгдэх үгсийг бүрэн багтаасан англи хэлний тайлбар толь бичиг нь англи хэл сонирхогчид болон англи хэлээр ерөнхий эрдэмд суралцагчдад төгс гарын авлага болж чадна. Энэ толь бичиг нь хэл сурахад дөхөм болох практик

зааварчилгаа, дагалдах интерактив CD- нь уг толь бичгийг бүхэлд нь хамруулахын зэрэгцээ дасгалууд, бүх үгсийн дуудлага болоод өөрийнхөө дуудлагыг шалгахад зориулсан дуу хураах, тоглуулах функц агуулсан ажээ.

81.2Анг-4

Ч-17

/БШУН унш-5ш, НХШУН унш-10ш/

Б-20886-20890

АМАН БОЛОН УТГА ЗОХИОЛ СУДЛАЛ

Цэрэнсодном Д. **Монгол аман зохиолын тайлбарт дээж бичиг** /Хян. Б. Катуу, Т. Баясгалан. – УБ.: Тод бичиг, 2011. – 744 хууд.

Аман зохиолын 15 төрлийг хамарсан энэхүү тайлбарт дээж бичгээ их, дээд сургуулийн монгол хэл бичиг, соёл урлагийн салбарын оюутан, багш нарт чухал гарын авлага болохын хамт эх хэл, аман зохиол, урлаг соёлоо эрхэмлэгч өргөн олон уншигчдад ч мөн хэрэгцээтэй бүтээл болж өгнө.

82.3/1/-6

Ц-96

/НХШУН унш-25ш/

Т-14707-14711



Мөнхбаяр Б. **Монголын уран зохиолын тайлбар толь**. –УБ.: 2011. -593х.

Энэхүү толь бичгийг зүйлчилсэн тайлбар толийн зарчмаар бичсэн ба эхний хэсэгт уран зохиолын онолын асуудлыг монголын эрт, өдгөөгийн уран зохиолын болон аман зохиолын жишээ баримтанд тулгуурлан авч үзсэн бол, 2-р хэсэгт Монголын уран зохиолын хөгжлийн түүхийг нэн эртний, эртний, ХХ зууны уран зохиол гэсэн хүрээнд, монголын уран зохиолын цаг цагийн гол гол төлөөлөгчийн уран бүтээлийн хамтад нь авч үзсэн ба нийтдээ 290 гаруй асуудлыг сонгон

тайлбарлажээ.

83.3/1/я2

М-81

/НХШУН унш-25ш/

Т-14809-14813

Хөвсгөл С. **Равжаагийн “Саран хөхөөний намтар” жүжгийн зохиолын шинжлэл, бичвэр судлал** /Хян. Д.Цэрэнсодном. –УБ.: Бемби сан, 2011. -720х.

Зохиолч энэ сэдвээр 2005 онд шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан бөгөөд тэрхүү диссертация ном болгон толилуульж байна. Үүнд “Саран хөхөөний намтар”-ын 1962 оны мөн Дорноговь аймгийн Равжаа судлалын музейд байгаа 10 дэвтэр хэвлэлийг голлон ашигласан ба тухайн зохиолын галиг, гэрэл зургуудыг оруулж өгчээ.

83.3/1/

Х-53

Т-14784-14786



УРАН ЗОХИОЛ



Баатар Т. **Зэрлэгийнхэн**: Бэсрэг роман. –УБ.: Жиком пресс, 2011. -365х.


84/1/-44

Б-11

Б-20918-20920

Баатар Т. **Эргэж хөрвөх хорвоо-1**: Роман. –УБ.: 2011. -240х.
84/1/-44
Б-11

Б-20921-20922



Болдбаатар Д. **Дияан**. –УБ.: Соёмбо принтинг, 2011. -196х.
Дияан нь Чана хэмээх самгарьд дуудлага бөгөөд аглаг сэрүүнд сууж анхаарлаа төвлөрүүлэх замаар оюун санааг орчлонгийн хүлээснээс ангижруулж, улмаар гэгээрлийг олох Бурханы шашны нэгэн гол аргын нэг ажээ. Толилуулан буй эл номонд дияанч нарын үйл амьдралтай холбоо бүхий бидний үед уламжлагдан ирсэн аман домгийн заримаас өгүүлэх болно.

84/1/2
Б-54

/НХШУН унш-3ш/

Б-20891-20892

Жу Яо Тин. **Чингис хаан**: Түүхэн роман. /Орч. Д.Болдбаатар. –УБ.: 2011. -621х.
84/5Хят/-44
Ж-82

/НХШУН унш-7ш/

Б-20858-20860



Чюн Яо. **Сюэко бүсгүй**. Роман. /Орч. Д.Болдбаатар. –УБ.: 2011. -188х.

84/5Хят/-44
Ч-98

/НХШУН унш-3ш/

Б-20893-20894

ШАШИН СУДЛАЛ


Баасан Д. **Богд Жавзандамба хутагт** /Ред. Д. Алтанцэцэг. – УБ.: Мөнхийн үсэг, 2011. – 572 хууд.

Баасан ламын энэхүү бүтээлд Богд Жавзандамба хутагтын I-IX дүрүүдийн намтар түүхийг цуглуулж эмхтгэн олны хүртээл болгон гаргаж байна. Мөн үүнд монгол түүхэн бичлэгийн ном дэвтэрт буй бичгүүд нь багтсан ажээ. Монгол улсын 800 жилийн түүх ялангуяа 1911 оноос хойших өнөөдрийг хүртлэх орчин цагийн монголчууд бидний өвөг дээдэс, бурхан шашин түүний удирдагч монгол туургатны авах гээх, буян нүглийг ялган заан сургагч, буян номонд, удирдан хөтлөгч, эртний ерөөлт лам багшийнхаа гайхамшигт амьдрал эрхэм үйлсийг нь танилцуулахыг гол зорилго болгон уншигч түмэндээ хүртээж байна.

86.35
Б-10

/НХШУН унш-8ш/

Т-14704-14706





Дашдондов Ц. **Шашны нэр томъёоны шинэ толь**: Монгол-Англи /Хян. Э. Пүрэвжав. – УБ.: Мөнхийн үсэг, 122 хууд.

Шашны шинэ энэ дүймэнг харь газар зорих гэж байгаа хэн бүхэнд зориулж монгол-англи хэлийг хослуулж, хялбар халаасандаа хийж явахад тань бүтээжээ.

86.3я2

Д-39

/НХШУН унш-7ш/

Б-20938-20940

Фрэйзер Ж.Ж. **Алтан гишүү** /Орос хэл. Орч. Ж. Отгонбаяр, Ред. А. Энхмаа, Ч. Мөнхтуяа. – УБ.: Монсудар, 2011. – 781 хууд.

“Алтан гишүү” хэмээх энэхүү номын үндсэн гол зорилго нь Арици хотын Дионогийн сүмийн тахилчийн албан тушаал хэрхэн өвлөгддөг тухай дэг журмыг тодорхойлогч хачирхалтай дүрэм горимыг тайлбарласан явдал юм.

86.41

Ф-93

/НХШУН унш-7ш/

Б-20992-20994



ФИЛОСОФИ



Гомбосүрэн Ц. **Философи**: Сурах бичиг: 2 дахь хэвлэл. –УБ.: Артсофт, 2011. - 494х.

Их, дээд сургууль, коллежийн оюутан сурагчдад зориулагдсан энэхүү сурах бичиг нь анх 2008 онд хэвлэгдсэн бөгөөд энэ удаад номондоо дахин нэмэлт, засвар хийж, философийн олон чухал бүрэлдэхүүнийг авч үзсэн нилээд хэдэн бүлэг нэмж дахин толилуулж байна.

87я73

Г-53

/НХШУН унш-45ш/

Т-14752-14756

Нагаанбуу Н. **Монголчуудын язгуур гүн ухаан**: Мартуулал: Харуусал /Ред. Ч. Ган-Өлзий, Тү. Өлзий, Д. Баяндалай, Ц. Буяндэлгэр, Б. Энх-Өлзий. – УБ.: Соёмбо принтинг, 2011. – 410 хууд.

Монголчуудын язгуур гүн ухаан хэмээх бүтээлдээ улс үндэстнүүдийн ижилсэл,

ондоошлын асуудал нь дэлхий нийтийн анхаарч буй өнөө үед монголчууд бид өрөөл бусдын ухааныг хүндлэхийн зэрэгцээ өөрсдийн гэсэн монгол язгууртай бүхнээ сэргээн тодруулах явдал зайлшгүй гарч байна. Түүхч, зохиолч Н. Нагаанбуу нь монголчуудын язгуур гүн ухааны асуудлаар анх удаагаа ном бичээд та бүнхий өмнө дэлгэн харуулж байна.

87.3/1/

Н-15

/НХШУН унш-15ш/

Т-14769-14770



Тэйлор С.Э. **Хайрлагдах нууц**: Хайр, секс, дурлалын ерөнхий хуулиуд /Орч. У. Нямсүрэн, Ч. Цэдэвсүрэн, Б. Баттөмөр. – УБ.: 2011. – 251 хууд.

Энэ номд тайлбарлахдаа өгүүлж байгаа энергийн үйлчлэл нь квантын тулгуур зарчмуудад үндэслэгдсэн бөгөөд тэдгээрийн үндсийн үндэс нь долгион ба цэнэгт хэсгүүд юм. Цэнэгт хэсгүүд энергийн долгион цацруулдгийг, гэрлийн долгионыг ч цэнэгт хэсгүүдийн адилаар хэмжиж байдгийг нээсэн нь физикийн ертөнцийг

донсолгосон байхийн. Квантын физик ертөнц дэх харилцаануудын талаар итгэмээргүй гайхамшигт нээлтүүд хийгдэжээ. Физик ертөнцийн энергийн энэ үзэгдэл бие хүний төвшинд хэрхэн холбогдож, нөлөөлөнө вэ гэдгийг л тайлбарлан гаргаж өгчээ.

87.7

T-30

/НХШУН унш-7ш/

Б-20964-20966

СЭТГЭЛ СУДЛАЛ

Бага насны хүүхдийн сэтгэл судлал /Ред. Ж.Батдэлгэр. –УБ.: 2011. -334х.

Сургуулийн өмнөх боловсролын сургуулийн оюутан, хүүхдийн цэцэрлэгийн багш арга зүйч, клиник профессор, эцэг эхчүүдэд зориулагдсан энэ номонд бага насны хүүхдийн сэтгэл судлалын үндсэн асуудлууд, хүүхдийн сэтгэцийн хөгжлийн онолын үндэс, ургийн болон нярай, нялх насны хүүхдийн сэтгэл зүй, бага насны хүүхдийн сэтгэцийн үйл явц, сэтгэцийг хөгжүүлэх аргууд, бага насны хүүхдэд илрэх хямралын шинж, түүнийг даван туулах, хүүхдийг сэтгэл зүйн хувьд сургуульд бэлтгэх тухай дэлгэрэнгүйгээр авч үзжээ.




88.8

Б-12

/НХШУН унш-3ш/

T-14841-14842



Друнвало М. **Амьдралын цэцэгийн эртний нууц**. 1-р боть /Орч. Г.Бат-эрдэнэ. – УБ.: 2008. -336х.

Мельхиседик Друнвало сүүлийн 25 жилийн туршид итгэл үнэмшлийн тогтолцоо болон шашны шүтлэгт суралцаж байгаа ажээ. Уншигч та түүний “Амьдралын цэцэгийн эртний нууц” семинарын энэ номыг уншсанаар сэтгэл судлалын ертөнцөд нэвтэрч, өөрийнхөө дотор гүнд байгаа зүйлээ эргэн санаж, та хэн бэ, та энд яах гэж ирсэн, энэ дэлхий дээр байгаа таны зорилго юу вэ гэдгээ санаж ойлгох болно.

88.2

Д-76

T-14843

Дэлгэржав М. **Сурган хүмүүжүүлэх сэтгэл судлал**: Сурах бичиг. – УБ.: Соёмбо принтинг, 2011. – 224 хууд.


Энэхүү сурах бичиг нь сурган хүмүүжүүлэх ухаан, сэтгэл судлалын салбарт судалгаа шинжилгээ хийж буй их, дээд сургуулийн оюутан, магистрант, докторант, судлаач, багш нарт зориулж байна.

88.4я73

Д-88

/НХШУН унш-3ш/

Б-20956-20958



НОМ ЗҮЙН БҮРТГЭЛ



МУИС-ийн ХҮС-д данстай ном /1924-2010/. – УБ.: Соёмбо принтинг, 2010. – 486 хууд.

ХҮС-д данстай эдгээр номнуудыг номын зохиогч, бүтээлийн нэр, хэвлэгдсэн газар, он, нийт хуудас зэрэг нэг бүрчилсэн бүртгэлийн дагуу жагсаажээ. Мөн номын сангийн програмын номын код /НК/, номын дансны дугаар /НДД/-ыг, эрдэм шинжилгээний номын сан /ЭШНС/, сургалтын номын сан /СНС/, гэрээр олгох номын сан /ГОНС/, чөлөөт сонголттой номын сан /ЧСНС/, гэж бүрэн

тэмдэглэж өгөхийн хамт монгол, орос, англи хэлээр бүлэг болгожээ.


91

М-69

T-14740

Монголын түүх судлалын ном зүй. 1-6 дэвтэр /Эмх. Э.Жигмэддорж. Ред. Ж.Урангуа. –УБ.: Соёмбо принтинг, 2011.


“Монголын түүх судлалын ном зүй” хэмээх 6 боть энэхүү бүтээлд Хүннү гүрэн байгуулагдсан үеэс эхлэн 1921 оныг хүртэлх Монголын улс төр, нийгэм, эдийн засаг, соёл, аж ахуйн түүхийг судалсан Монгол улсын судлаачдын судалгааны бүтээлийг хамруулжээ. Ном зүйд хамтын бүтээл, нэгэн сэдэвт зохиол, эрдэм шинжилгээний өгүүлэл, тэмдэглэл, хурлын материал, өгүүллийн эмхэтгэл, ном зүйн бүртгэл гэх мэт бүтээлийг зүйлчлэн монгол хэлний цагаан толгойн үсэг, зохиогчийн нэр, хэвлэгдсэн оны дарааллаар жагсаажээ.



91.9:63

/НХШУН унш-2, Лав.ф-1ш/

М-69	1-р боть: Монголын эртний түүх судлалын номзүй.	Б-20830-20831
	2-р боть: Их монгол улс, эзэнт гүрний түүх судлалын ном зүй.	Б-20832-20833
	3-р боть: ХIY-ХYII зууны үеийн Монголын түүх судлалын ном зүй.	Б-20834-20835
	4-р боть: ХYII-ХХ зууны үеийн Монголын түүх судлалын ном зүй.	Б-20836-20837
	5-р боть: Олноо өргөгдсөн Монгол улсын түүх судлалын ном зүй.	Б-20838-20839
	6-р боть: Монголын түүх бичлэг, сурвалж судлалын ном зүй.	Б-20840-20841



Мөнх-Амгалан Ю, Кунай М. **МУИС-ийн ЭШБ-ийн ном зүйн бүртгэл: 3-р дэвтэр /2002-2008/** /Хян. Р. Самъяа, Д. Саранцэцэг. – УБ.: УИХ-ын Тамгын газрын хэвлэх, 2010. – 308 хууд.

Энэхүү эрдэм шинжилгээний ном зүйн бүртгэлд МУИС-ийн бүрэлдэхүүний болон салбар сургууль, факультетаас 2002-2008 онд эрхлэн хэвлүүлсэн эрдэм шинжилгээний бичгийн болон оюутны эрдэм шинжилгээний бүтээлийн эмхтгэлийн нийт 225 цуврал бичгийг хамруулж, бүгд 3892 өгүүллийг бүртгэн

оруулж өгчээ.

91:9:7

М-81

/НХШУН унш-3ш,Лав-1ш/

Б-20902-20904

ОРОС ХЭЛ ДЭЭРХ НОМ

Евразийский мир: ценности, константы, самоорганизация /Под ред. Ю.В.Попкова. – Новосибирск, Нонпарель, 2010. – 449 стр.

В монографии на основе переосмысления наследия представителей классического евразийства анализируются ценности, константы и проблемы самоорганизации евразийского мира. Выводы авторов опираются на результаты эмпирических исследований в различных локусах евразийского мира /Южная Сибирь, Казахстан, Монголия, Калмыкия, евразийские сообщества за рубежом/. К монографии прилагается словарь концептов классического евразийства. Книга рассчитана на философов, культурологов, социологов, этнологов, политологов, историков, на всех, кому небезразличны идеи евразийства и судьба евразийского мира.



60.59/051/

Е-22

С-84704



О.М.Ковалевскийн бүтээлийн дээжис. Цуврал ботиуд: Орос хэл дээр. –Казань. 1837.

Нэрт монголч эрдэмтэн О.М.Ковалевскийн мэндэлсний 210 жилийн ойд зориулан түүний зохиол бүтээлийг “О.М.Ковалевскийн бүтээлийн дээжис” цуврал ном болгон эрдэмтэн, судлаачдын хүртээл болгон толилуулж байна.

Буддийская космология: Изложенная. -171с.

С-84700-84701

Монгольская хрестоматия. -592с.

82

К-56

С-84702-84703